




**“ДАРХАН-УС СУВАГ”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2016 ОНЫ АЖЛЫН
ТАЙЛАН**



Боловсон хүчний талаар:


Ажиллаж буй боловсон хүчин

- хөдөлмөрийн гэрээгээр-209
- түрээсийн гэрээгээр-42
- олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны-20



Боловсролын байдал

- дээд-94
- бүрэн дунд-72
- тусгай дунд-31
- бүрэн бус дунд-11




ТУС КОМПАНИД НИЙТ 271 АЖИЛТАН АЖИЛЛАЖ БАЙНА



Боловсон хүчний талаар:


Ажиллагсдын тогтвор суурьшил

- 1-5 жил-84
- 6-10 жил-41
- 11-15 жил-19
- 16-20 жил-20
- 20 дээш жил-45



Хүйсийн харилцаа


- эрэгтэй-125
- эмэгтэй-84



Боловсон хүчний талаар:


Ажилтнуудын дундаж нас

■ Ажилтнуудын тоо



Боловсон хүчний талаар:

АЖИЛТНУУДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН






ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН




2016 оны жилийн эхнээс
2622,2 м/м³ ус олзворлож,
1570,4 м/м³ усны борлуулалт
хийсэн. Төв цэвэрлэх
байгууламжид **2119,9** м/м³ ус
татан зайлуулж, **1696,3** м/м³
усны борлуулалт хийсэн.



2016 оны цэвэр усны татан зайлуулалт, борлуулалтыг өмнөх онтой харьцуулсан график /м.м3/



2016 оны бохир усны татан зайлуулалт, борлуулалтыг өмнөх онтой харьцуулсан график /м.м3/




- 2016 онд жилийн эхнээс их ба урсгал засварын нэгдсэн графикийг гарган, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар их засвар **83%**-тай, урсгал засвар **92.6%**-ийн биелэлттэй байна.
- 2016 оны жилийн эхнээс ОСАлба нь цэвэр усны гэмтэл **447**, бохир усны бөглөрөл **1638**, айл өрхийн **3322** дуудлагыг барагдуулж **15,9** сая төгрөгийн орлогыг оруулж ажилласан байна.
- Нэгдсэн лаборатори нь цэвэр усны **908**, бохир усны **426**, гадны **60** шинжилгээнд **2536,8** мян/төгрөгийн төлбөрт шинжилгээг хийсэн.
- Техникийн нөхцөл авах хүсэлт тавьсан **75** өргөдөл хүсэлтээс **50** техникийн нөхцөлийг гаргаж **4,6** сая гаруй төгрөгийн орлогыг оруулжээ.




2016 онд гадны хэрэглэгчдэд авто машин механизмаар 3069,0 мянган төгрөгний үйлчилгээ, мөн автогражид компанийн ажилтнуудын автомашинныг гэрээгээр тавиулснаар 2370,0 мянган төгрөгийг тус тус компанид оруулсан байна.

Үйлчилгээний орлогыг өмнөх онтой харьцуулсан график /сая.төг/



Тоолуур суурилуулалт, туршилт тохируулгын тоон харьцуулалт



2016 оны жилийн эцсийн байдлаар айл өрхийн 97%, аж ахуйн нэгжийн 98% тоолууржсан байна.



2016 онд айл өрх, ААН-д тоолуур суурилуулалт болон туршилт тохируулга хийсэн ажлын мэдээ


Төрөл	Айл өрх, ААНэгж	Суурилуулсан тоолуур	Орсон орлого /мян.төг/
Айл өрх	647	937	5602,0
ААН	80	90	
ДҮН	727	1027	

Төрөл	Айл өрх, ААНэгж	Туршилт, тохируулга хийсэн тоолуур	Орсон орлого /мян.төг/
Айл өрх	940	1685	14158,4
ААН	286	366	
ДҮН	1226	2051	



2016 оны байдлаар айл өрх болон аж ахуйн нэгжийн 241 цэгт 11387 м³ цэвэр ус, 9569 м³ бохир усны торгууль тавьж 21,5 сая төгрөгийн алданги тооцон 87% буюу 18,8 сая төгрөгийг компанид оруулсан байна.

Айл өрх, ААН-д алданги тооцсон мөнгөн дүнг өмнөх онтой харьцуулсан график /сая. төг/




2016 онд нийт УХА нь 76, ОСА-нь 32 удаагийн аваар гэмтлийг арилгаж, хэвийн горимд нь оруулж ажиллаа. Аваар гэмтлийн тоо өмнөх оноос 34,3 хувиар буурсан байна.




Цэвэр усны алдагдал нь өмнөх оноос
буурсан нь улсын төсвийн хөрөнгө
оруулалтаар 3 цэгт 1000 гаруй метр, орон
нутгийн болон өөрийн байгууллагын
хөрөнгөөр 1352 метр газарт цэвэр усны
шугам хоолойн шинэчлэлт хийгдсэн нь
аваар гэмтлийн тоо багасч усны алдагдал
буурсан болно.



УХА, ОСА-ны шугам хоолойн аваар гэмтлийн тоог өмнөх онтой харьцуулсан график



2016 оны цэвэр, бохир усны дундаж алдагдлыг харьцуулалт



Энэ онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Альянс Тех” ХХК нь 3 цэгт 1000 гаруй метр шугамыг сольж, үүнд компанийн ИТАжилтнууд хяналт тавьж ажиллалаа.

Хуучин дарханд Турк сургуулийн дэргэдээс Камасервис хүртэл цэвэр усны d100 мм-ийн шугамыг 150 м сольсон.



ПолиТехникийн коллежийн урд цэвэр усны d200 мм-ийн шугамыг 200 м сольсон.



Хуучин дарханд Харигаас Энэрэл цогцолбор сургууль хүртэл d150 мм-ийн цэвэр усны шугам



2016 оны жилийн эхнээс 2016-2017 оны өвлийн оргил ачааллын үед Дархан сумын бүх үйлдвэр ААНБ-ууд, хэрэглэгчдийг цэвэр усаар хангах, бохир шингэнийг татан зайлуулах үндсэн үйл ажиллагаагаа найдвартай тасралтгүй явуулахын тулд “Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө”-г батлуулан ажилласан.

Төлөвлөгөөнд нийт 24 ажил хийхээр тусгасан. “Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө”-ний явцын мэдээ, хэрэгжилтийг сар бүрийн 25-ны дотор Барилга Хөгжлийн Төв, аймгийн Захирагчийн Ажлын албанд хавсралтын дагуу гарган өгч ажиллалаа. 2016 онд өвөлжилтийн бэлтгэл ажлын биелэлт **87.5 %-тай** хангагдсан.



Үйлдвэрлэлийн ажлын хүрээнд хийгдсэн ажлууд:

Усан хангамжийн албаны 1-р өргөгчийн №3, 8, 10-р худгуудын, 2-р өргөгчийн №2-р насосонд засварын ажлыг хийж, худаг №3-т шинээр хөдөлгүүр ороолгон № 8,16-р худгуудыг өвлийн оргил ачааллын үед ажиллуулахаар бэлтгэлд тавьсан.





- ТЦБ-ийн Агаарын 4-р насосд 160 кв 2950об/мин цахилгаан хөдөлгүүр шинээр угсарч ажилд оруулсан.



- Төв станцын №5 насосны суурин дээр CM200/150/500 маркийн насосыг шинээр угсарч ажилд оруулсан.



➤ **ТЦБ-ийн Аэротенкийн 3-р секцийг цэвэрлэж, өвлийн горимд ажиллахад бэлэн болголоо.**



Бохир усны төв болон салбар шугам хоолойн хавар, намрын угаалгыг графیکیн дагуу хийж 15 цэгт хурдгийн өндөрлөгөө, засварын ажлуудыг хийлээ.



- ✓ Байгууллагын конторын дээврийн ажлыг шинээр засварласан.
- ✓ Манаачийн өрөөний ажлын байранд засварын ажил хийгдсэн.
- ✓ Нарийн хэмжүүр туршилт тохируулгын өрөөг тендерийн ажлаар шалгаруулж шинээр засварласан.



2016 онд төв болон салбар шугам сүлжээний шинэчлэлт

№	байршил	диаметр	урт/м/	алба
1	Мангирт хорооны төв шугам	d100	132	УХА
2	Буудай зочид буудлын дэргэд	d100	24	УХА
3	6-р хороолол 16-р байрны оруулга	d100	20	ОСА
4	Бохир ус дамжуулах 2-р станцын цэвэр усны шугам	d25	350	ОСА
5	Бохир ус дамжуулах 2-р станцын халаалтын шугам	d50	700	ОСА
6	6-р хороолол 13-р байрны оруулга	d100	36	ОСА
7	6-р хороолол 23-р байрны оруулга	d76	66	ОСА
8	хэ/х 42-р байрны дэргэд төв шугам	d200	66	УХА
9	1-р хороолол 31,32-р байрны оруулга	d100	72	ОСА
10	21-р хороолол 17-р байрны оруулга	d89	72	ОСА
11	21-р хороолол 17-р байрны оруулга	d100	36	ОСА
12	1-р хороолол 23-р байрны оруулга	d100	66	ОСА
13	5-р хороолол 5.3-р байрны оруулга	d100	108	ОСА
14	301-р байрны оруулга	d100	30	ОСА
15	ТЦБ-ын толгой орой дээрх	d200	40	УХА
16	1-р хороолол 38,39-р байрны оруулга	d100	72	ОСА
17	20-р хороолол 4-р байрны подваль	d89	132	ОСА
18	5-р хороолол 1а подвальд	d76	30	ОСА
	Нийт		2052	



Өнөөдрийн байдлаар Усан хангамжийн төв болон салбар шугам сүлжээний нийт 18 цэгт **2052** метр шугам хоолойг шинээр сольж, шугам хоолойн шинэчлэлт хийлээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө болох 27 сая төгрөгөөр дараах цэгүүдэд шинэчлэлтийг хийсэн. Үүнд:

- 1-р хорооллын 38, 39-р байрны оруулга d100 мм-ийн шугам-72 метр
- хэ/х 4.2-р байрны дэргэд төв шугам d200 мм-ийн шугам- 66 метр
- 20-р хорооллын 4-р байрны подвальд d89 мм-ийн шугам -132 метр
- 6-р хорооллын 23-р байрны оруулга d76 мм-ийн шугам -66 метр




Хэ/хо-ын 4.2-р байрны дэргэдэх төв d200мм-ийн шугам хоолойн шинэчлэлтийн ажлын явцаас



Шинэ хорооллын 13-р байрны дэргэдэх төв d100 мм-ийн шугам хоолойн шинэчлэлтийн ажлын явцаас




**Хуучин Дарханы 20.4-р байрны зоорийн давхарт
цэвэр усны $d89$ мм-ийн шугам хоолойг 132м
шинэчилсэн.**



Хуучин хороололын 38,39-р байранд зоорийн давхарт цэвэр усны $d100$ мм-ийн шугам хоолойг 72м шинэчиллээ.



Хэвтэй хороололын 5-р хороололын 3-р байрны зоорийн давхарт цэвэр усны d200 мм-ийн шугам хоолойг d100мм болгон 198м шинэчилсэн.



АТА-ны 2-р станцын халаалтын болон хүйтэн усны шугам хоолойг шинэчлэлээ.



2016 онд нийт 63ш хаалт, галын гидрантыг сольсон байна.



2016 онд шинээр сольсон хаалт, винтелийн жагсаалт

№	Алба	Диаметр /мм/	Сольсон хаалт, винтелийн тоо ширхэг
1	Усан хангамжийн алба	d50-200	22 ширхэг хаалт 2 ширхэг галын гидрант
2	Ариутгах татуургын алба	d150-400	4 ширхэг хаалт
3	Орон сууцны алба	d50-100	35 ширхэг хаалт



12 сарын байдлаар ОСА-нд нийтийн орон сууцны байруудад шугам хоолой хөлдсөнийг гэсгээж ,хэвийн горимд нь оруулж ажилласанаас дурдвал:

- 17.11-р байранд d50мм хаалт хөлдсөн
- 23.2-р байрны d25мм шугам хөлдсөн
- 50-р бракийн d15мм шугам хөлдсөн
- 35-р бракийн d15мм шугам хөлдсөн
- 17.13-р байрны d50мм бохирын шугам хөлдсөн
- 4.1-р байрны 2-р орцонд d20мм босоо шугам хөлдсөн




“ДАРХАН ХОТЫН БОХИР УСНЫ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ МОН 3244/3245 ” ТӨСӨЛ

- Азийн хөгжлийн банкны 20.68 сая долларын хөнгөлттэй зээлийн санхүүжилтээр “ДАРХАН ХОТЫН БОХИР УСНЫ МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ МОН 3244/3245 ” төсөл хэрэгжиж, тендерийн бичиг баримт боловсруулагдсан.
- 2016 оны 10 дугаар сараас эхлэн төслийн үйл явц төлөвлөгөөт хугацааны дагуу явагдаж байна.
- Дархан-Уул аймгийн засаг даргын А/445 тоот захирамжийн дагуу аймгаас томилогдсон ажлын хэсэг сар бүрийн сүүлийн 7 хоногт төслийн үйл явц болон дараа сард хийх ажлуудаа төлөвлөн батлуулж ажиллаж байна.



ТӨСЛИЙН ҮР ДҮН -1



ТЦБ бүрэн шинэчлэгдэнэ. Технологийн шинэчлэлт хийгдсэнээр түүхий лагийг **метантенкэд** боловсруулан биохий үйлдвэрлэх юм. Үйлдвэрлэн гаргасан биохийг ашиглан Цэвэрлэх байгууламжийн цахилгаан болон дулааны тодорхой хувийг өөрсдөө хангах бололцоотой гэсэн дүгнэлтэнд хүрч байна.





САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ





Байгууллагын сүүлийн 4 жилийн хугацаанд хуримтлагдсан алдагдал /төг/

№	Үзүүлэлт	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,649,808,400	3,099,027,600	3,466,966,200	3,734,056,900	3,634,708,326
2	Нийт зардал	3,541,903,200	3,790,265,100	4,273,813,300	4,518,417,100	4,587,956,528
3	Нийт ашиг алдагдал	(892,094,800)	(691,237,500)	(806,847,100)	(784,360,200)	(953,248,202)
4	Бусад орлого	-	1,930,800,200	594,253,600	123,416,400	159,360,612
5	Бусад зардал	-	2,215,101,400	336,105,000	477,926,400	248,246,451
6	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(892,094,800)	(975,538,700)	(548,698,500)	(1,138,870,200)	(1,042,134,041)
	Нийт дүн					(4,597,336,241)



Нийт орлого зарлага /сая.төг/

■ Борлуулалтын орлого ■ Нийт зардал



1м3 усны дундаж үнэ, өөрийн өртөг

Ангилал			Усны үнэ /төг/		Өөрийн өртөг
			Аймгуудын дундаж	Дархан-ус суваг	
Цэвэр ус	Айл өрх	тоолууртай	1033	780	1680
		тоолуургүй	2562	900	
	ААН	тоолууртай	2638	1300	
			2077	993	
Бохир	Айл өрх	тоолууртай	830	850	1348
		тоолуургүй	2225	1000	
	ААН	тоолууртай	2216	1400	
			1757	1133	
Цэвэр ус	Зөөврөөр хангах ус		1979	1000	3405



Айл өрх, ААНэгжийн усны хэрэглээ / м3 /

Хэрэглээ		2014 онд Нийт	2015 онд Нийт	2016 онд Нийт	2014 оноос буурсан	Хувь
Цэвэр ус	ААН-н бичилт	742,624	517,434	515,964	(226,660)	-30.5
	Айл өрхийн бичилт	1,142,304	1,142,317	1,031,552	(110,752)	-9.7
	Худаг	49,210	51,842	51,100	1,891	3.8
	Цэвэр усны дүн	1,934,137	1,711,594	1,594,653	(339,484)	-17.6
Бохир ус	ААН	725,176	624,963	673,254	(51,922)	-7.2
	Айл өрх	1,172,123	1,179,114	1,053,234	(118,889)	-10.1
	Бохир усны дүн	1,897,299	1,804,076	1,604,607	(292,692)	-15.4



Авлагын тооцоо /сая.төг/

Тайлант үе: 2016 он

№	Дансны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		Дебет	Дебет
1	Дансны авлага	33,5	23,9
2	Дансны авлага-орон сууцны хэрэглэгчдээс авах усны авлага	0	0
3	Дансны авлага-ААНэгжийн усны авлага	302,6	304,2
4	Дансны авлага-айл өрхийн усны авлага	712,4	704,8
5	Дансны авлага-мангиртын усны авлага	72,0	82,3
6	Усны авлага- худаг	0,9	0
7	Ажилтнуудаас авах авлага	7,6	10,0
8	Хувь хүмүүсээс авах авлага	0	2,0
9	Дансны авлага-урьдчилгаа цалин	13,9	0,2
10	Дараа тайлангийн авлага–дансны авлага	187,5	205,5
11	Компани хоорондын авлага	13,5	0
	НИЙТ ДҮН:	1,344,8	1,333,2



Өглөгийн тооцоо /сая.төг/

Тайлант үе: 2016 он

№	Байгууллагын нэр	Оны эхэнд	Оны эцэст
1	ДСЦТС ХК-цахилгааны үнэ	348,5	508,0
2	Дансны өглөг- бараа материалын өглөг	191,8	216,2
3	Ажилтнуудад өгөх өглөг	38,8	51,7
4	Цалингийн өглөг	23,9	30,1
5	Усны нөөц ашигласан татварын өглөг	31,9	20,2
6	НДШимтгэлийн өглөг	208,6	326,2
7	Хаяг тодорхойгүй усны төлбөр төлсөний өглөг	12,9	12,3
8	ҮЭвлэлийн татварын өглөг	12,3	16,6
9	ХХОАТатварын өглөг	44,9	48,0
10	НӨАТатварын өглөг	192,3	391,2
11	Урт хугацаат зээл	279,6	205,1
12	Бусад өглөг	36,3	42,5
	НИЙТ ДҮН:	1 422,2	1 868 ,4




2013-2016 оны Үндсэн үйл ажиллагааны зардал ба 2017 оны зардлын төлөвлөлт /төг/

№	Утга	2013 он	Хувь	2014 он	Хувь	2015 он	Хувь	2016 он		Хувь	2017 он	
								Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Хувь
1	Нийт зардал	3,789,032,558		4,304,214,000		4,290,656,722		4,443,984,072	4,587,956,528		4,349,501,344	
1.1	УХА	1,019,777,304	26.91	1,175,782,000	27.32	1,111,437,026	25.90	1,116,416,067	1,074,844,978	24.35	1,059,844,147	23.77
1.2	АТА	871,663,709	23.00	915,045,000	21.26	966,473,203	22.53	997,284,044	1,077,765,551	24.42	1,010,689,506	22.67
1.3	ОСА	298,429,451	7.88	352,037,000	8.18	381,463,482	8.89	389,046,943	408,107,481	9.25	396,320,894	8.89
1.4	ТШҮА	865,013,282	22.83	935,418,000	21.73	904,037,155	21.07	934,696,062	981,685,481	22.24	902,684,379	20.24
1.5	ЛАБ	70,595,169	1.86	84,338,000	1.96	90,626,583	2.11	92,086,535	88,660,923	2.01	83,941,694	1.88
1.6	ХА	304,613,424	8.04	364,825,000	8.48	361,437,887	8.42	380,572,959	408,933,499	9.26	382,600,878	8.58
1.7	ТУЗ	11,663,500	0.31	23,880,000	0.55	31,105,535	0.72	36,413,800	31,215,059	0.71	36,037,280	0.81
1.8	ЗАА	347,276,719	9.17	452,630,000	10.52	444,075,851	10.35	452,594,562	516,743,556	11.71	477,382,566	10.71



2013-2016 оны Үндсэн үйл ажиллагааны зардал ба 2017 оны зардлын төлөвлөлт

№	Утга	2013 он	хувь	2014 он	хувь	2015 он	хувь	2016 он	хувь	2017 он	хувь
								гүйц		төл	
1	Цалин	1 058 799 034	27,94	1 334 225,000	31,00	1 536 548 664	35,81	1 568 338 854	35,33	1 564 585 089	35,09
2	НДШимтгэл	146 788 974	3,87	189 474,000	4,40	217 631 904	5,07	221 801 877	5,00	203 396 062	4,56
3	Түүхий эд материал	399 880 050	10,55	478 486,000	11,12	293 457 165	6,84	344 102 328	7,75	313 687 188	7,03
4	Шатахууны зардал	159 526 021	4,21	155 458,000	3,61	146 494 529	3,41	136 432 616	3,07	139 580 695	3,13
5	Элэгдлийн зардал	1 079 349 506	28,49	1 091 005,000	25,35	1 075 000 000	25,05	1 177 903 613	26,54	1 144 684 408	25,67
6	Дулаан	16 351 637	0,43	17 168,000	0,40	22 500 000	0,52	21 418 095	0,48	20 678 391	0,46
7	Цахилгаан	572 081 347	15,10	611 843,000	14,21	670 454 711	15,63	705 067 963	15,89	669 717 321	15,02
8	Хоол унаа	65 997 327	1,74	77 165,000	1,79	99 566 333	2,32	103 047 220	2,32	98 957 595	2,22
9	Хөдөлмөр хамгаалал	44 570 740	1,18	46 800,000	1,09	50 618 381	1,18	54 828 438	1,24	57 281 752	1,28
10	Бусад зардал	245 687 922	6,48	302 590,000	7,03	178 385 035	4,16	105 610 236	2,38	136 932 842	3,07
	ДҮН	3 789 032 558		4 304 214,000		4 290 656 722		4 438 551 239		4 349 501 344	




Тусламж тэтгэмжинд 104.9 сая төгрөг зарцуулав.

- ❖ Ажилтнуудад тусламж, дэмжлэгэнд 4.6 сая төгрөг
- ❖ Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтнуудын тэтгэмжинд 70.4 сая төгрөг
- ❖ Өндөр настнуудын хүлээн авалтанд 22,7 сая төгрөг
- ❖ Ажилтнуудын сувилалын эрхийн бичгийн хөнгөлөлтөнд 526.0 мян төгрөг
- ❖ Шинээр хүүхэдтэй болж, гэр бүл болсон ажилтнуудад 2,1 сая төгрөг



Хамтын гэрээний дагуу ажилтнуудад нийт 36 удаагийн тэтгэмж олголоо.



Ажилтнуудын нийгмийн асуудлын хүрээнд:

- ❖ Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэлд-6.8 сая төгрөг хүнд
- Ажилтнуудын илүү цагийн хөлсөнд-74,6 сая төгрөг
- Хор саармагжуулах бүтээгдэхүүнд-9,7 сая төгрөг
- Хоол, унааны зардалд-10.2 сая төгрөг тус тус зарцуулсан.



Сургалт, шинэ техник технологитой танилцах ажилд нийт 33.4 сая төгрөг зарцууллаа. Үүнд:

Төлөвлөгөөт сургалтанд 11.7 сая төгрөг зарцуулав.



Ажилтнуудыг шинэ техник технологитой танилцуулах ажилд 18.7 сая төгрөг зарцуулав.



Залуу ажилтнуудад “Амжилтын үндэс” цогц сургалт явуулж, төрийн ордонтой танилцуулахад 3,2 сая төгрөг зарцууллаа.



Тус компани нь ISO 9001:2015 /MNS 9001:2016 стандартын шаардлагын дагуу Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхээр зорилт тавин, төслийн ажлыг 4 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



- ❖ ISO 9001:2015 стандартын шаардлагад нийцсэн Чанарын менежментийн тогтолцоог компанийн хэмжээнд бий болгож, баримтжуулж, хэрэгжүүлэх, хэвшүүлэх, энэхүү тогтолцоог тасралтгүй сайжруулан Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ISO 9001:2015 (MNS 9001:2016) батламжтай байгууллага болох ба НААҮ-ий салбарын байгууллагуудын дунд ISO нэвтрүүлсэн анхны байгууллага болох юм.



Биеийн тамир спорт:

Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллага үүсч хөгжсөний 85 жил, Дархан хотын 55 жилийн ойн баярын хүрээнд байгууллагын ажилтнуудын дунд спортын олон төрөлтийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Нийтийн аж ахуйн салбарын 85 жилийн ой, Төвийн бүсийн НАА-н байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлэх, салбарын ажилчдын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор урлаг спортын тэмцээн 05 сарын 19-21-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал суманд болж, манай компани багаараа 2-р байр эзлэв.



Аймаг орон нутгаас зохиосон ажилд:



❖ 2016 оны 04-р сард “Ухаалаг Соёлтой сэдэвт нээлттэй оролцов. хэрэглээ-үйлчилгээ” хэрэглэгчийн өдөрлөгт


❖ 2016 оны 09-р сард Дархан хотын 55 жил, МНААҮ-ий салбар үүсч хөгжсөний 85 жилийн ойн “Нээлттэй хаалганы өдөр”-т оролцож, компаниа сурталчлах, иргэдэд үйлчлэх ажлуудыг зохион байгуулав.



Дархан хотод хэрэгжиж буй "Шарилжгүй Дархан" аяны хүрээнд өөрийн компанийн эргэн тойрны шарилжийг цэвэрлэж, бусад станц ажлын байруудын шарилжийг цэвэрлэх ажлыг үе шаттайгаар зохион байгууллаа.



- ❖ Дархан хотын 55 жилийн ойг угтсан "Нийтийн цэвэрлэгээ"-ний ажлыг 2016.09.29-ний өдөр 8-р багт өөрийн байгууллагын эргэн тойрны 60 метр хүртлэх талбайг 70 хүний бүрэлдэхүүнтэй цэвэрлэж, 13-р багийн нутаг дэвсгэр дээр орших 2-р өргөгч станц, малчин багийн нутаг дэвсгэр дээр орших Төв цэвэрлэх байгууламжийн ойр орчимд нийт 80 хүний бүрэлдэхүүнтэй 8000 орчим метр кв талбайг цэвэрлэж 1 самосвал хог ачин хогийн цэг дээр асгуулсан. 2016 оны 09-р сарын 30 нд 7-р багийн цэвэрлэгээнд эксковатор, самосвал машинаар үйлчилсэн.



**Байгууллагын ахмадууд өөрсдийн санаачилгаар Усны эх
булгийн орчны хогийг цэвэрлэж, 6 м³ хогийг ачиж
зайлууллаа. Цаашид уламжлал болгон жилд 2 удаа цэвэрлэгээ
хийхээр ахмадууд санаачилга гаргалаа.**



“Хүчирхийллийн эсрэг хамтдаа нэгдэцгээе” уриан дор байгууллагаараа нэгдлээ.

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтаж “Усны хэмнэлттэй хэрэглээ” сэдэвт гар зургийн уралдаан явууллаа.



Дархан-Уул аймгийн “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-аас зохион байгуулсан “Залуучуудын хөгжил ба бидний ирээдүй” үндэсний хэлэлцүүлэгт залуучуудаа оролцуулж санал бодлоо илрэхийлэв.

Эрүүл мэндийн яамнаас “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө” үндэсний салбар дундын зөвлөлдөх уулзалтанд амжилттай оролцож саналаа тусгав.



Монгол улсад НААҮ-ий салбар үүсч хөгжсөний 85 жилийн ой, салбарын ажилтнуудын баярын өдрийг байгууллага хамт олноороо тэмдэглэлээ. /Шагнал, бусад зардалд 15 сая төгрөг зарцуулав/



МНААҮ-ий салбарын байгууллагуудаас “Байгальд ээлтэй хамт олон” номинацид шалгарч “Өргөмжлөл”, 2.5 сая төгрөгөөр шагнууллаа.



**Манай хамт олон АЗТГ, Худалдаа
аж үйлдвэрлэлийн танхимаас жил
бүр шалгаруулдаг “ОНЫ ОНЦЛОХ” аж
ахуй нэгжээр шалгарлаа**

**“Ажил олгогч эздийн холбооны” 2016
оны шилдэгийн шилдэг Ажил олгогч
байгууллага**



КОМПАНИЙН 2017 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВЬСАН ЗОРИЛТУУД:

- ❖ Усны алдагдлыг 18%-д барих
- ❖ Үйл ажиллагааны зардлыг бууруулах
- ❖ Цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлж хэрэглэгчдийн тоог өсгөх
- ❖ Санхүүгийн алдагдлыг бууруулах



2017 оны гол зорилтоо биелүүлэхийн тулд дараах ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж байна: Үүнд:

- Гэмтэлтэй байгаа төв цэвэр усны кольцо шугам хоолойнуудыг засварлаж ажилд оруулах.
- Аж ахуйн нэгжийн тойрог шугам хоолойнуудыг таслах.
- 6-8-р сарын үед өндрийн болон 2-р өргөгчийн усан сангуудыг ээлжлэн угаах.
- Аж ахуйн нэгж, ОСБ-уудын айл өрхийг тоолууржуулах ажлыг үргэлжлүүлэн хийх
- Орон сууцны хуучин хорооллын 31-р байрны 1,2-р орцны хүйтэн, халуун усны тоолууруудыг зоорийн давхарт нэгтгэж суурилуулах.



- Аж ахуйн нэгжийн тоолуурыг 3D, 5D стандартад оруулах
- Ухаалаг худгийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх
- Цэвэр усны алдагдлыг 2016 оны дундаж түвшинд барьж ажиллах
- Гэмтэл олон давтамжтай гарч байгаа ус хангамжийн шугам хоолойнуудыг Улсын болон орон нутгийн төсөв, өөрийн компанийн хөрөнгөөр шинэчлэх ажлуудыг төлөвлөж байна.



Айл өрхийн тоолуурыг зоорийн давхарт нэгтгэн суурилуулах



Манай байгууллага 2017 оны бизнес төлөвлөгөөнд өөрийн хөрөнгөөр айл өрхийн тоолуурыг зоорийн давхарт нэгтгэн суурилуулах ажлыг үе шаттайгаар хийхээр төлөвлөсөн.

Гарах үр дүн:

- ➔ ✓ Бодит хэрэглээг тогтооно.
- ➔ ✓ Төлбөр тооцооны хуримтлал үүсэхгүй.
- ➔ ✓ Өр авлага буурна.
- ➔ ✓ Усны алдагдал буурна.
- ➔ ✓ Хэрэглэгчдэд хүндрэлгүйгээр усны бичилтийг тогтсон хугацаанд хийгдэнэ.




ГЭР ХОРООЛЛЫН УС ТҮГЭЭХ БАЙРУУДЫГ УХААЛАГ СИСТЕМД ШИЛЖҮҮЛЭХ

Гэр хорооллын усан хангамжийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, ундны усны хэрэглээг нэмэгдүүлэх, нэг литр усанд оногдох үйлчилгээний өртгийг бууруулах зорилгоор 2017 онд компанийн бизнес төлөвлөгөөнд өөрсдийн хөрөнгөөр 2 ус түгээх байранд ухаалаг төхөөрөмжийг суурилуулахаар төлөвлөсөн.




Давуу тал:

- Хэрэглэгч 24 цагийн турш үйлчилгээ үзүүлэх боломжтой.
- Нэг хүний хоногийн усны хэрэглээ нэмэгдэнэ.
- Борлуулалт өснө
- Гэр хорооллын усан хангамжийн зардал буурна.



АЙЛ ӨРХ, АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД УСНЫ УХААЛАГ ТООЛУУР НЭВТРҮҮЛЭХ

Техник технологийн дэвшил өөрчлөлтөөр хүмүүсийн хэрэглээнд **Ухаалаг системүүд нэвтэрч** байна. Мэдээллийн технологийг ашиглан айл өрхийн усны тоолуурыг алсын зайнаас удирдах, тоолуурын мэдээллээ цуглуулах, хянах хэрэгцээ шаардлага үүсч байна.



Давуу тал:

- Алсын зайнаас таслах хаалтыг удирдах боломжтой /Хаах, нээх/
- Жилийн мэдээллийг сар, сараар хянах
- Соронзонгийн нөлөөлөлд автахгүй
- Алсын зайнаас мэдээлэл авах боломжтой
- Wireless, M-BUS, RF холболтуудыг дэмждэг.




ДАРАЛТ ТОХИРУУЛАХ ХААЛТ СУУРИЛУУЛАХ

Цэвэр усны шугам сүлжээний усны зардал, даралт жигд бус байгаагаас хуучирсан шугам хоолойд гэмтэл гарах, усны алдагдал ихсэх зэрэг үргүй зардал байнга гарч байдаг. Иймд даралт тохируулах хаалтыг шугам сүлжээнд байрлуулах шаардлагатай .


Давуу тал:

- ✓ Усны алдагдал буурна.
- ✓ Усан хангамжийн сүлжээнд даралтын тохируулга хийгдэнэ.
- ✓ Даралтын хэт их ачаалалаас шугамын гэмтэл гарах эрсдэл буурна.
- ✓ Ус хангамжийн шугам сүлжээний ачаалалыг диспетчерийн төвд хянах боломжтой болно.



ХЭТИЙН ТӨЛӨВ

“УСАН ХАНГАМЖИЙН СҮЛЖЭЭНД ДАРАЛТ ТОХИРУУЛАГЧ ХААЛТ СУУРИЛУУЛАХ



ХООЛНЫ ДАВСНААС ХЛОР ГАРГАН АВАХ ТЕХНОЛОГИ

Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2011 онд Усан хангамжийн насос тоног төхөөрөмжийн 75 хувьд шинэчлэл хийгдсэн. Манайд хлоржуулах байгууламж нь шингэн хлор ашигладаг. Энэ нь үнэ өртөг өндөр, тэсэрч дэлбэрэх, хлор алдагдах аюултай байдаг. Иймд хоолны давснаас хлор гаргах технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Давуу тал:

- Тэсэрч, дэлбэрэх аюулгүй.
- Ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй.
- Энгийн хоолны давс ашигладаг тул түүхий эдийн хомсдолд орохгүй.
- Электролизын аргаар 0,1%-ийн идэвхтэй гипохлорит натрийн уусмал гаргадаг тул халдваргүйжүүлэлтийн явцад хорт хавдар үүсгэгч тригалометан/хлороформ/бодис үүсгэдэггүй.



ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТУУД:

1. Усны үнэ тарифийг үе шаттайгаар нэмэгдүүлж 1м3 усны өөрийн өртөгт ойртуулах
2. Одоо ашиглагдаж байгаа болон хэтийн төлөвлөлтөөр хийгдэх усан хангамж, ариутгах татуургын шугам хоолойг шинэчлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх
3. Ус түгээх байруудад дэвшилтэт технологийг нэвтрүүлэн ухаалаг худгийн төхөөрөмжийг суурилуулах
4. Аж ахуйн нэгж, айл өрхөд ухаалаг тоолуур суурилуулах
5. Усан хангамжийн шугам сүлжээнд даралт тохируулах хаалтууд суурилуулах
6. Хоолны давснаас хлор гарган авах технологи нэвтрүүлэх
7. ЦЭХ-ний чадлын болон дэмжих тарифт хөнгөлөлт үзүүлэх асуудлыг холбогдох багууллагуудад тавьж шийдвэрлүүлэх



АНХААРАЛ

ХАНДУУЛСАНД

БАЯРЛАЛАА

